

# ТОЙМ

---



**ОЛОН УЛСЫН  
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.05.13

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

2024 он 05-р сарын 13

- БНХАУ-ын инфляцын түвшин 0.3% гарсан нь хүлээлтээс дээгүүр үзүүлэлт боллоо.
- Alibaba компанийн шинэ AI загвар болох Qwen2.5 нь OpenAI-ийн GPT-4 загвараас чадварын хувьд илүү гэлээ.
- Варрен Баффетийн Berkshire Hathaway сангийн бэлэн мөнгөний хэмжээ 189.9 тэрбум ам.доллар буюу түүхэн дээд түвшинд хүрлээ.
- Дэлхийн эдийн засаг HARD-LANDING сценард орохгүй гэж нийт сангийн менежерүүдийн 93.0% нь үзэж байна.

Dow Jones	39,512.84
S&P 500	5,222.68
Nasdaq	16,340.87
DAX	18,756.86
FTSE 100	8,433.76
S&P/ASX 200	7,743.20
HANG SENG	19,065.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.32%	1.70%	4.03%	4.84%	18.65%	14.92%
S&P 500	0.16%	0.81%	1.94%	9.49%	26.64%	25.13%
Nasdaq	-0.03%	-0.05%	1.02%	8.86%	33.02%	21.67%

2024 оны 05 сарын 13-ны 11:30



Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	0.38%	3.20%	4.61%	11.97%	17.87%	21.67%
FTSE 100	0.63%	2.68%	5.48%	9.06%	8.76%	19.74%

2024 оны 05 сарын 13-ны 11:30



Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	-0.25%	0.60%	-0.76%	1.82%	6.51%	10.19%
Hang Seng	0.60%	2.67%	14.07%	11.89%	-2.82%	-31.95%

2024 оны 05 сарын 13-ны 11:30





## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

S&P 500 индекс гурван долоо хоног дараалан өсөж, бүх цаг үеийн дээд цэгтээ ойртож ирлээ. Бусад голлох индексүүд ч мөн өссөн ба тэр дундаа үнэ цэний төрлийн хувьцаанууд илүүтэйгээр өсөлт үзүүлжээ. Өнгөрсөн долоо хоногт зах зээл маш бага хэмжээний арилжаа хийгджээ. Ялангуяа өнгөрсөн долоо хоногийн Лхагва гараг энэ жилийн хамгийн бага арилжаа хийгдсэн өдөр болжээ.

Ерөнхийдөө нам гүм, арилжааны идэвх багатай долоо хоног байсан ч эхний улирлын ашгийн тайлан гарч зарим хувьцаанууд огцом хөдөлсөн. Мягмар гарагт Уолт Диснейн хувьцааны үнэ 9.5%-иар унасан. Тус компани орлого хүлээлтдээ хүрсэн ч онлайн стриминг бизнест захиалагчдын өсөлт удааширч болзошгүйг нь гол унах шалтгаан болжээ. Үүний нэгэн адил орлогын өсөлт удааширна гэсэн таамаглал нь лхагва гарагт Shopify онлайн худалдааны платформын хувьцааны ханш 18.6 хувиар буурахад хүргэсэн юм.

Өнгөрсөн лхагва гарагт дууссан долоо хоногт ажилгүйдлийн тэтгэмж хүссэн хүмүүсийн тоо 231,000 болж өссөн нь өнгөрсөн наймдугаар сараас хойших хамгийн өндөр үзүүлэлт юм. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн урьдчилсан индекс 67.4 болж буурсан нь сүүлийн зургаан сарын хамгийн доод түвшинд хүрсэн гэж мэдээлсэн. Хэрэглэгчид ирэх онд инфляц, ажилгүйдэл, зээлийн хүүгийн түвшин таагүй чиглэлд шилжиж магадгүй гэж санаа зовж байгаагаа илэрхийлэв.

### График 1: Алтны ханшийн төлөв байдал ба техник шинжилгээ



Алт хамгийн сүүлд үүсгэсэн нам оройг давж арилжаалагдсан тул богино хугацааны чиг хандлага өсөлт рүү шилжсэн гэж харж болохоор байна. Эхний ээлжид өсөлтөөр 2404 орчим хүрэх бол дунд хугацаанд өсөлтөөр 2600 орчим ханш руу хүрэх боломжтой байна.





## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

**Аялал жуулчлалын орлого өслөө:** Хөдөлмөрчдийн өдрийн баярын үеэр аялал жуулчлалын орлого 7.6%-иар өссөн нь 2023 оны мөн үе болон ковидын өмнөх үеийнхээс өндөр байгааг БНХАУ-ын Аялал жуулчлал, Соёлын яамнаас мэдээллээ. Дотоодын аялал жуулчлалын орлого өнгөрсөн оноос 12.7%-иар өсөөд байна.

**Гадаад худалдааны үзүүлэлт хүлээлтээс давлаа:** БНХАУ-ын экспорт 4-р сарын байдлаар 1.5% өссөн байна. Зүүн өмнөд Азийн орнуудад хийсэн экспортын дүн өсөөд байгаа бол Европын улс орнуудад хийсэн экспорт буурах хандлагатай байна. Харин импортын дүн 8.4% өссөн нь хүлээлтээс дээгүүр үзүүлэлт болж байгаа ба импортын өсөлт нь хэрэглэгчдийн худалдан авалт өссөнөөс бус түүхий эд материалын татан авалт нэмэгдсэнтэй холбоотойгоор үүссэн гэж харж байна.

**Инфляцын түвшин 0.3% гарсан нь эрэлт өссөнийг илтгэж байна:** БНХАУ-ын хэрэглээний үнийн индекс 3 сар дараалан өсөлттэй гарсан нь эрэлт нэмэгдэж буйг илэрхийлж байна. БНХАУ-ын инфляцын түвшин 4-р сард 0.3% гарсан бол үйлдвэрлэлийн үнийн индекс 2.5% гарлаа. Шинжээчдийн хэлж буйгаар БНХАУ-ын дотоод эрэлт нэмэгдэж байна. БНХАУ-ын хэрэглээний үнийн индекс 3 дахь сар дараалан өссөн нь эдийн засгийн эрэлт өссөнийг харуулж буй бол үйлдвэрлэгчийн үнийн индекс буурсан нь эдийн засаг сайн дүр зурагтай байгааг илтгэж байна.

### График 2: ICBC хувьцааны ханшийн график ба техник шинжилгээ

INDUSTRIAL & COMMERCIAL BK OF CHINA, 1W, HKEX O:4.53 H:4.56 L:4.52 C:4.53 0.00 (0.00%)



Industrial and Commercial Bank of China (1398:HKEX) хувьцааны техник үзүүлэлтүүд:

- 2007 оноос хойш ICBC банкны хувьцааны бодит ханш буюу хамгийн их арилжаа хийгдсэн ханш нь 4.28-5.95 HKD-ийн хооронд арилжаалагдаж байна.
- Арилжаалагдсан түүхэн хэмжээсийг харвал өсөлтийн эхний хэмжээ 4.74 HKD, дараагийн хүрэх хэмжээ 5.15 HKD-д байна.
- Хэрэв ICBC банкны хувьцааны ханш 5.15 HKD-д хүрсэн тохиолдолд Доугийн онолоор урт хугацааны өсөлтийн трендэд орох ба боломжит дээд ханш 5.95 HKD байна.

## ТАЙЛАНГИЙН ХУАНЛИ

### Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS W WHISPERS		Most Anticipated Earnings Releases									
		for the week beginning									
		May 06, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
 spirit	 Palantir	 Disney	 RIVIAN	 Uber	 arm	 ROBLOX	 MARATHON PETROLEUM	 INSPIRED	 ENBRIDGE	 DigitalOcean	 AMC NETWORKS
 BIONTECH	 Symbotic	 CELSIUS	 ARISTA	 shopify	 Robinhood	 GIGAMONADS TECHNOLOGY	 SoundHound	 axsome	 LUCID	 crocs	 Wynn Resorts
 Krystal	 hims hers	 DATADOG	 Upstart	 affirm	 airbnb	 WARNER BROS. DISCOVERY	 CLEANSPARK	 unity	 AMC NETWORKS	 ROAD & TRIKE	 POLARIS
 Tyson	 REALITY INCOME	 NIKOLA	 lyft	 Avadel	 theTradeDesk	 unity	 RICHMOND REALTY HOLDINGS INC.	 unity	 AMC NETWORKS	 ROAD & TRIKE	 POLARIS
 JLL	 AXON	 bp	 twilio	 TOYOTA	 BEYOND MEAT	 Constellation	 VUZIX	 sphere	 NOW	 HEI	 CRM
 ALPHA METALLURGICAL RESOURCES	 MICROCHIP	 Rockwell Automation	 toast	 EMERSON	 APPOVIN	 SUNDIAL GROUP	 CALIBER REAL ESTATE	 indie	 ADMA	 HEI	 CRM
 NAPCO	 VERTEX	 Builders FirstSource	 reddit	 ECHOSTAR	 ENERGY TRANSFER	 CRONOS GROUP	 CanadianSolar	 ADMA	 HEI	 CRM	 CRM
 freshpet	 teradata	 JUMIA	 confluent	 Perion	 duolingo	 EXACT SCIENCES	 VIATRIS	 NUSCALE	 HEI	 CRM	 CRM
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>											